



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/45

Шивээговь сум

**Золбин нохой, муур устгах
 ажил зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10 дугаар “Сумын 2022 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Сумын хэмжээнд золбин нохой, муур устгалын ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Золбин нохой, муур устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ц.Цэрэндорж

(Засаг даргын Тамгын газрын даргын
 үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Д.Сувд-Эрдэнэ

(1 дүгээр багийн Засаг дарга)

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

Л.Цэнд-Аюуш

(Нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга:

Т.Өлзийбуд

(Байгаль орчны асуудал хариуцсан
 мэргэжилтэн)

3. Золбин нохой, муур устгалын ажилд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

4. Золбин нохой, муур устгалын ажилд зарцуулагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг “Байгаль хамгаалах, орчны бохирдлыг бууруулах-хоггүй сум” арга хэмжээний зардлаас зохих журмын дагуу гаргахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

5. Ажлыг чанартай зохион байгуулж, тайланг гарган танилцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2022 оны 04 р
сарын 15 ний өдрийн
А/45 захирамжийн хавсралт



Золбин нохой устгах ажлын төсөв

Д/Д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Нохой, муур устгал	ш	100	20.000	2.000.000
Нийт өртөг					2.000.000